



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 05 өдөр

Дугаар 4484

Зуунмод

Газар эзэмших эрх шилжүүлж,
газрын байршил өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р багт Энхжин хотхон, хуучин Өлзийт оёдлын үйлдвэрийн урд байрлалтай иргэн Сүрэнжав овогтой Дорждамбын эзэмшиж байгаа 200 м2 газрын байршилыг өөрчилж Номт 1-р баг, Жишиг хороолол 2-ын хойд талд 200 м2 гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэн Буяндэлгэр овогтой Аюуш /МЮ40070182/-д 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн Б.Аюушд дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүдэг газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиглах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын дарга /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Зуунмод сумын Засаг даргын 2000 оны 10 дугаар сарын 13-ны 151 дүгээр захирамжийн С.Дорждамбад холбогдох хэсгийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

010 00437

My.doc-Zahiramj-2019-03